

**“МОНГОЛ ШИР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар 01

2017 оны 12-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**Компанийг өөрчлөн байгуулах тухай**

“Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол, хурлын хэлэлцүүлэг, ТУЗ-ийн 2017 оны 4 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шир” Хувьцаат компанийг “Монгол шир” Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулсугай.
2. Компанийг өөрчлөн байгуулах төсөл, компанийг өөрчлөн байгуулахтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төсөл баталсантай холбогдуулан холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороо, бусад эрх бүхий байгууллагуудад хүргүүлж зөвшөөрөл аван шийдвэрлүүлэхийг Төсөл хэрэгжүүлэх комисс /Б.Батсайхан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЯМЦЭРЭН

**“МОНГОЛ ШИР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар 02

2017 оны 12-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**Нэгж хувьцааны үнийг тогтоох тухай**

“Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол, хурлын хэлэлцүүлэг, ТУЗ-ийн 2017 оны 7 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийг өөрчлөн байгуулснаар хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах зах зээлийн үнийг 2714 төгрөгөөр тогтоохыг Төлөөлөн удирдах зөвлөл /Н.Нямцэрэн/ -д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЯМЦЭРЭН

**“МОНГОЛ ШИР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар 03

2017 оны 12-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**Компанийн дүрмийг батлах тухай**

“Монгол шир” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит БУС хурлын Тооллогын комиссын тогтоол, хурлын хэлэлцүүлэг, ТУЗ-ийн 2017 оны 4 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өөрчлөн байгуулалтын үр дүнд үүсэх “Монгол шир” ХХК-ийн дүрмийг нэг дүгээр хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЯМЦЭРЭН